



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 5 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар
хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 12.1.15, 46.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын төвийн Баруун Зуунмод багийн 3.5 км, Баянхошуу багийн 2.5 км хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах 3.3 (гурван тэрбум гурван зуун сая) тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны нэмэлт орлогод зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын нийт төсөвт өртгийн үлдэгдэл болох 1.549.9 (нэг тэрбум таван зуун дөчин есөн сая есөн зуун мянган) сая төгрөгийг Монгол Улсын 2018 оны төсвийн төсөлд тусган шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат нарт даалгасугай.

3. Авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч, авто замын чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргалд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН